



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 211/А/1290318

Мандалговь

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Адаацаг сумын Байгаль хамгаалах сангийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитаар санхүүгийн тайлан дахь өндөр насжилттай 2,550,000.00 /Хоёр сая таван зуун тавин мянган/ төгрөгийн албан байгууллагад өгөх өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т /Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.7-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Санхүүгийн тайлан дахь өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж байх.

Дээрх давтан гаргахгүй байх хууль тогтоомжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэхийг Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг дарга Ч.Уранчимэг, нягтлан бодогч Ө.Уранбилэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

Д.ДОЛЖИНСУРЭН

БАТАЛГААЖУУЛСАГ

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

<sup>1</sup> Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70592208